

Америкийн Түүхээс

Хойд Америк дахь Британий колониуд 1776 онд салан тусгаарлаж, улмаар 1783 оны Парисын Гэрээний дагуу Америкийн Нэгдсэн Улс бусад улс орноор хүлээн зөвшөөрөгджээ.

1787 онд батлагдсан Үндсэн хуулийн дагуу АНУ нь холбооны улс болж анхлан байсан 13 муж улс дээр XIX, XX зууны туршид шинээр 37 муж улс нэмэгдсэн тул тус улс Хойд Америкийн ихэнхийг эзэлсэн томоохон гүрэн болон өргөжжээ.

1861-1865 онд дэгдсэн Иргэний дайн болон 1930-аад оны эдийн засгийн Их хямралын үе нь АНУ-ын түүхийн хамгийн эгзэгтэй үе хэмээн үздэг байна. Дэлхийн I, II дайнд байгуулсан ялалт болон 1991 онд өндөрлөсөн Хүйтэн дайнаас хойш АНУ нь дэлхийн хамгийн хүчирхэг гүрний статусаа хадгалсаар байна.

Америкийн Эдийн засаг

АНУ нь дэлхийн хамгийн том, технологийн хувьд хөгжсөн хүчирхэг эдийн засагтай бөгөөд нэг хүнд ҮНБ нь 37,600 америкийн доллар аж. Тус улсын зах зээлийн эдийн засгийн тогтолцооны дагуу худийн бизнес давамгайлах үүрэгтэй бөгөөд холбооны болон төрийн байгууллагууд шаардлагатай бараа, үйлчилгээг эдгээр хувийн үйлдвэрлэгчээс худалдан авдаг системтай байна. Баруун Европ, Японы аж үйлдвэрлэгчидтэй харьцуулбал америкийн бизнес эрхлэгчид нь капитал болон үйл ажиллагааны хэмжээг өргөжүүлэх, ажиллах хүч нэмэгдүүлэх, шинэ бараа бүтээгдэхүүн боловсруулахад давуу талтай байна. АНУ-ын компаниуд нь компьютер, ангаах ухаан, сансар судлал, батлан хамгаалах зэрэг салбарын тоног төхөөрөмж боловсруулалтаараа дэлхийд тэргүүлдэг байна. 1994-2000 онд бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрс нэмэгдэж, инфляцийн түвшин багасч, ажилгүйдлийн хэмжээ 5 хувиас доор болов. Харин 2001 оноос АНУ-ын эдийн засгийн өсөлт нь саарч байна.

ҮНБ – 10,45 триллион америкийн доллар

ҮНБ-ний өсөлт – 2,4 хувь /2002 оны байдлаар/

Нэг хүнд ноогдох ҮНБ-ний хэмжээ – 37,600 америкийн доллар

ҮНБ-ний бүтэц – Хөдөө аж ахуй 2 хувь

Аж үйлдвэр 18 хувь

Үйлчилгээний салбар 80 хувь

Ажиллах хүч – 141,8 сая хүн

АНУ-ын эдийн засаг хурдацтай хөгжиж эхэллээ



АНУ-ын эдийн засаг хурдацтай хөгжиж эхэллээ. АНУ-ын эдийн засгийн байдал энэ оны 7-9 дүгээр сарын хооронд хоёр хувиар нэмэгджээ. Мөн 4-6 дугаар саруудад 1.7, жилийн эхний хагаст 3.7 хувиар өссөн байна. Эл өсөлт нь эдийн засагчдын үзэж буйгаар зах зээлийн өрнөл болон ажил хаялтаас ангид бие даан хөгжсөн үзүүлэлт гэнэ.

Өнгөрсөн долоо хоногт Америкийн төв банк тус улсын санхүү, эдийн засгийн байдлыг цаашид улам хөгжүүлэхийн тулд шинэ алхам хийх боломжтойг мэдэгджээ. Төв банк уг төлөвлөгөөнийхөө хүрээнд ирэх сард их хэмжээний мөнгөн тэмдэгт худалдан авч зах зээлд нэвтрүүлэхээр зэхэж байна. Нөгөөтэйгүүр тус улсад ажилгүйдлийн төвшин 9.6 хувиар нэмэгдсэн аж. Иймээс ихэнх америкчууд ирээдүйдээ итгэлгүй байгаа нь харагдаж буй. Ажиглагчдын үзэж буйгаар ард түмний сэтгэлийн хямрал нь ирэх мягмар гаригт болох сонгуульд нөлөөлөх магадлалтай. Түүнчлэн Ерөнхийлөгч Барак Обамагийн Ардчилсан намын гишүүд их хурлын нийт суудлын гуравны нэгээс илүү хувийг эзлэх магадлал өндөр байгаа аж. Энэ оны сонгууль Ерөнхийлөгч Б.Обамагийн эдийн засгийн бодлогыг шүүх нэгэн томоохон шалгуур болох гэнэ.

АНУ-ын эдийн засаг ганхах төлөвтэй байна

АНУ-ын Холбооны бэлтгэл комиссын нийтэлсэн тайлангаас үзвэл тус улсын эдийн засгийн сэргэлт зохих хэмжээгээр сайжирч, ойрын хугацаанд эдийн засгийн нэмэгдлийн хурд дахин түргэсэх аж. Гэвч эдийн засгийн сэргэлт нь олон эрсдэлтэй тулгарч байгаа аж. Тайланд харуулснаар сүүлийн үед эдийн засгийн хөгжлийн байдалд, аж үйлдвэрлэлийн хэмжээ болон оршин суугчдын зарлага нэмэгдсэн, хөдөлмөрийн зах зээлийн байдал сайжирсан зэрэг нааштай үр дүн илэрчээ. Гэвч, тус улсын орон сууцны зах зээл өсөлт муутай байж, байрны үнэ үргэлжлэн унаж мэдэх аж. Үүний зэрэгцээ аж ахуйн эзэд ажилтнуудынхаа цалинг нэмэгдүүлэх дургүй байгаа гэнэ. Мөн Европын зарим улсын өр ширийн хямрал зэрэг нь АНУ-ын банк санхүү болон эдийн засагт сөргөөр нөлөөлж мэднэ гэж Холбооны бэлтгэл комисс сэрэмжлүүлжээ.

АНУ-ын эдийн засаг хурдацтай хөгжиж эхэллээ



АНУ-ын эдийн засгийн байдал энэ оны 7-9 дүгээр сарын хооронд хоёр хувиар нэмэгджээ. Мөн 4-6 дугаар саруудад 1.7, жилийн эхний хагаст 3.7 хувиар өссөн байна. Эл өсөлт нь эдийн засагчдын үзэж буйгаар зах зээлийн өрнөл болон ажил хаялтаас ангид бие даан хөгжсөн үзүүлэлт гэнэ. Өнгөрсөн долоо хоногт Америкийн төв банк тус улсын санхүү, эдийн засгийн байдлыг цаашид улам хөгжүүлэхийн тулд шинэ алхам хийх боломжтойг мэдэгджээ. Төв банк уг төлөвлөгөөнийхөө хүрээнд ирэх сард их хэмжээний мөнгөн тэмдэгт худалдан авч зах зээлд нэвтрүүлэхээр зэхэж байна.

Нөгөөтэйгүүр тус улсад ажилгүйдлийн төвшин 9.6 хувиар нэмэгдсэн аж. Иймээс ихэнх америкчууд ирээдүйдээ итгэлгүй байгаа нь харагдаж буй. Ажиглагчдын үзэж буйгаар ард түмний сэтгэлийн хямрал нь ирэх мягмар гаригт болох сонгуульд нөлөөлөх магадлалтай. Түүнчлэн Ерөнхийлөгч Барак Обамагийн Ардчилсан намын гишүүд их хурлын нийт суудлын гуравны нэгээс илүү хувийг эзлэх магадлал өндөр байгаа аж. Энэ оны сонгууль Ерөнхийлөгч Б.Обамагийн эдийн засгийн бодлогыг шүүх нэгэн томоохон шалгуур болох гэнэ.

Бернанке: АНУ-ын эдийн засаг 4.0 хувь хүрнэ



Америкийн эдийн засаг 2012 онд 4.0 болж өснө гэж Холбооны нөөцийн газрын дарга Бен Бернанке мэдэгджээ. “Манай улсын эдийн засаг энэ онд өмнөхөөсөө илүү сайжирна. Бидний тооцож буйгаар, эдийн засаг 3-4 хувь хүртэл өснө. Эдийн засгийг бэхжүүлж, ажилгүйдлийг бууруулах хөтөлбөр бүхий Засгийн газрын

600 тэрбум долларын бонд худалдан авах ажлыг хэрэгжүүлснээр 2011 оны 11 дүгээр сарын эхэн үе гэхэд өсөлт 3.0-3.6 хувь хүрнэ” гэж АНУ-ын Төв банкны дарга хэлжээ. Саяхан нийтэлсэн баримтаас харахад, АНУ-ын эдийн засгийн сэргэлт өнгөрсөн сарын үзүүлэлтээс ихээхэн нэмэгдсэн байна. Хэдийгээр эдийн засгийн сэргэлт өссөн ч ажилгүйдлийг бууруулах хангалттай хэмжээнд хүрээгүй байгааг Бернанке онцлон тэмдэглэжээ. Одоогоор АНУ-ын ажилгүйдлийн түвшин 9.4 хувь байгаа юм. АНУ-ын Төв банк хүүгийн хэмжээний талаар нэгдүгээр сарын 25-нд хуралдах бөгөөд энэ удаад тус улс мөнгөний бодлогодоо төдийлөн өөрчлөлт оруулахгүй гэж үзэж байна.

АНУ-ын эдийн засаг



АНУ-ын эдийн засаг бол дэлхийн хамгийн том эдийн засаг билээ. 2009 онд тус улсын ДНБ-ий хэмжээ ойролцоогоор 14.3 триллион байсан нь дэлхийн ДНБ-ий бараг дөрөвний нэг хувь аж.

Энэ нь тус улсын араас орох Япон улсын ДНБ-ий хэмжээнээс /4.4 триллион доллар/ гурав дахин их үзүүлэлт юм. Үүнээс гадна ДНБ-ий худалдан авах чадварын тэгш байдлаараа мөн дэлхийн хамгийн том нь юм. Түүнчлэн АНУ-ын эдийн засгийн нэг хүнд ногдох хувийн үзүүлэлтээр хамгийн өндөр түвшинд байдаг. 2009 оны байдлаар тус улсын нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ ойролцоогоор 46,381 доллар байсан нь хамгийн өндөр үзүүлэлттэй зургаа дахь улс болжээ.

Түүхийн үүднээс харахад, ДНБ-ий тогтвортой өсөлт болон ажилгүйдлийн түвшин бага, хөрөнгө оруулалтын түвшин өндөр байсан нь АНУ-ын эдийн засгийн гол түшээ тулгуур байжээ. АНУ 1944 оноос хойш дэлхийн хамгийн том эдийн засагтай улс болж, өдийг хүртэл дэлхийн хамгийн том бүтээгдэхүүн үйлдвэрлэгч /дэлхийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний гарцийн 19 хувийг бүрдүүлдэг/ гэсэн байр сууриа хадгалсаар иржээ.

Дэлхийн нийт саятанууд 30 хувь нь Америкт аж төрдөг гэсэн судалгаа гарчээ. Түүнчлэн дэлхийн нийт тэрбумтануудын 40 хувь нь америк хүн гэнэ. Үүнээс гадна АНУ-д дэлхийн хамгийн том хөрөнгө бирж болох Нью-Йоркийн хөрөнгийн бирж байрладаг билээ. Нэмж хэлэхэд дэлхийн хамгийн том 500 компанийн 139 нь Америкт үйл ажиллагаагаа төвлөрүүлэн ажилладаг бөгөөд үүнийг бусад улстай харьцуулахад хоёр дахин их үзүүлэлт юм. Энэ улсыг дэлхийн томоохон гүрэн болоход ихээхэн хувь нэмэр оруулсан зүйл бол яах аргагүй тус улсын гол мөнгөн тэмдэгт болох доллар билээ.

АНУ-ын доллар дэлхийн улс орны гадаад валютын нөөцийн 60 хувийг эзэлдэг гэсэн тооцоо гарчээ. Харин үүний гол өрсөлдөгч евро 24 хувийг эзэлдэг байна. Харин 1960 оноос хойш АНУ дэлхийн улс орнуудад хөрөнгө оруулалтаа өсгөж, дэлхийн хамгийн том

хөрөнгө оруулагч орны нэг болсон. Одоогоор дэлхийн хамгийн хүчирхэг эдийн засагтай орон АНУ-ын өр 13 триллион доллар хүрсэн бөгөөд зээлийн хүү нь өдөрт 5.48 тэрбум доллароор өсчээ. Харин 2010 оны сүүлийн улирлын байдлаар Америкийн Засгийн газар болон компаниудын нийт өр 50.2 триллион доллар болсон байна. Энэ нь ДНБ-ий хэмжээнээс 3.5 дахин их үзүүлэлт бөгөөд дотоод санхүүгийн актив хөрөнгө нь 131 триллион доллар, дотоодын санхүүгийн өр төлбөр нь 106 триллион доллар болжээ.

Америкийн хөдөлмөрийн зах зээл дэлхийн бараг бүх орны цагаачдыг өөртөө татдаг бөгөөд үүгээрээ дэлхийн хамгийн их цагаач иргэнтэй орны нэг болсон. Тус улс энэ үзүүлэлтээр 2008-2009 онд эхний байрт бичигдэж байсан ч эдийн засгийн хямралын улмаас дөрөвдүгээрт орсон болохыг Дэлхийн өрсөлдөх чадварын тайланд дурдсан байна. АНУ-ын эдийн засгийн түүх нь 16-18 дугаар зууны Европын колоничлолоос эхтэй аж. 180 онд АНУ өсөн тэлж, аж үйлдвэрлэлийг хөгжүүлснээр дэлхийн эдийн засгийн дөрөвний нэг хувийг эзлэх болжээ. Энэ амжилтын гол үндэс нь томоохон нэгдсэн зах зээл, улс төрийн дэмжлэгтэй хуулийн тогтолцоо, аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний томоохон газар нутаг, их хэмжээний байгалийн нөөц /ялангуяа ой мод, нефть, нүүрс/, байгалийн үзэсгэлэнт тогтоц, хүний капитал гэх мэт. Тус улсын эдийн засаг хэд хэдэн хямралтай нүүр тулж байсан ч 1893 оны хямрал нь хамгийн их хор уршигтай хямрал болжээ. Тухайн үед тус улсын ажилгүйдэл 10 хувь давж байжээ.

Одоо цагт Америкийн эдийн засаг дэлхийн хамгийн чухал зах зээлийн нэг хэвээр байгаа ч өрийн хямрал ихээхэн дарамт үзүүлж байна. Европын Холбооны зах зээл болон БРИК-ийн /Бразил, Орос, Энэтхэг, Хятад/ холбооны эдийн засаг ихээхэн хүчээ авч байгаа учир АНУ-ын дэлхийн эдийн засаг дахь ноёрхол бага багаар буурч байгаа. Ялангуяа Хятадын эдийн засгийн өсөлт ихээхэн хурдацтай байгаа бөгөөд ирэх 30 жилийн хугацаанд АНУ-ын ноёрхолыг тус улс өөртөө шилжүүлэн авна гэж мэргэжилтнүүд үзэж байгаа юм.

АНУ-д орон сууцны худалдаа болон зээлийн үйлчилгээнд доголдол гарснаар АНУ-ын эдийн засаг ихээхэн буурсан. 2007 онд тус улсын ДНБ-ийн өсөлт 2.2 хувь байсан бол 2008 онд энэ нь ердөө 0.9 хувь болсон нь 10 жилийн дундаж үзүүлэлт 2.8 хувиас ихээхэн доогуур хувь болжээ.

АНУ-ыг чөлөөт зах зээлтэй улс гэж үздэг ч энэ тийм ч бодит үнэн биш аж. Учир нь тус улсын Засгийн газар эрчим хүч, хөдөө аж ахуй зэрэг тодорхой хэдэн салбараа хамгаалах зохицуулалт хийснээр дээрх дүгнэлтийг гаргах болжээ. Үүнээс харахад АНУ хэрэглэгчийн эдийн засагтай гэж тодорхойлж болно.

АНУ-ийн эдийн засаг дэлхийн хамгийн том эдийн засаг болсноос хойш тус улсын худалдан авагчид эдийн засгийнхаа гуравны хоёр хувийг бүрдүүлж, дэлхийн эдийн засгийг урагш хөдөлгөгч томоохон бүлэг болжээ.

Мөнгө болон санхүүгийн бодлоготой хамааралтай шийдвэр гаргахад АНУ-ын эдийн засагт тус улсын Засгийн газрын үүрэг нэн чухал нөлөө үзүүлдэг. Холбооны Засгийн газар АНУ-ын өсөлт, тогтвортой байдлыг бэхжүүлэх шаардлагатай бүх санааг гаргадаг билээ. Америкийн Засгийн газар эдийн засгийн өсөлтийн зохицуулалт хийхдээ мөнгөний нийлүүлэлт, татварын хэмжээ, зээлийн хяналт зэрэг бүх арга хэрэгслийг ашигладаг байна. АНУ-ын Засгийн газар монополь байдал газар авахаас сэргийлэн хувийн аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааг мөн зохицуулдаг.